

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/029/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Энхдалай

Утас: 261628

Цахим хаяг: Enkhdalaid@audit.gov.mn

Аудитор :

М.Ганбаатар

Утас:261740

Цахим хаяг: ganbaatar.m@audit.gov.mn

Ажу мэргэн аудит ХХК-ийн захирал: Л.Насанбуян

Утас:99093142 Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/748
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 138,233.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Шуудангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалттай тус тус нийцэхгүй санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Тайлант онд 39,060.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын худалдан авах ажиллагааг төсөвт өртгийн хязгаар баримтлаагүй, 1 аж ахуйн нэгжээс шууд худалдан авсан;
- Ажилтнуудад нотлох баримтгүйгээр 40 цагийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгох тушаал гаргаж, нийт 39,984.7 мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан;
- Дотоодын шуудан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлгүй байгууллагатай гэрээ байгуулж, нууцын зэрэглэлтэй "Элсэлтийн ерөнхий шалгалт"-ын материалыг

хүргүүлэх, буцааж авах шуудан үйлчилгээний ажил гүйцэтгүүлж, 6,500.0 мянган төгрөг шилжүүлсэн;

- "Гүйцэтгэлийн үнэлгээний асуулга боловсруулах гэрээ"-ний дагуу нэр бүхий 20 мэргэжилтэнд 28,650.0 мянган төгрөг олгосноос 16 хүний тухайн ажлыг гүйцэтгэх шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг нотлох баримт, гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын үнэлгээний төв нь 71 орон тоотой ажиллахаас гүйцэтгэлээр 52 үндсэн хүн ажиллаж байгаа бөгөөд албан тушаалын тодорхойлолтод зааснаас гадна гэрээгээр нэмэлт ажил, үүрэг гүйцэтгүүлж боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийн төсөл арга хэмжээний зардлаас 557,473.2 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанарын хүртээмжийг дээшлүүлэх төслийн санхүүжилт 459,522.3 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлагаас 350,963.3 мянган төгрөг, нийт 844,624.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 570,398.8 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 274,225.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Боловсролын яам, Боловсролын үнэлгээний төв, Их Британийн AQA байгууллагын хооронд байгуулсан "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн дагуу хэрэгжүүлэх "Олон улсын үнэлгээний тогтолцоо, систем нэвтрүүлэх" төслийн хүрээнд хийгдсэн ажлын төлбөр 700,000.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр толилуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Боловсролын үнэлгээний төв нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	741,566,334.10	603,504,181.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	140,220.25	140,220.25
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	140,220.25	140,220.25
33	АВЛАГА	356,502,873.85	251,893,004.61
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	507,400.00	460,604.61
33300	Татаас санхүүжилтийн авлага	351,138,273.85	251,432,400.00
335	Бусад авлага	4,857,200.00	-
3351	Байгууллагаас авах авлага	4,857,200.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	384,923,240.00	351,470,957.00
351	Түүхий эд материал	124,812,477.00	94,551,987.00
35110	Тусгай зориулалттай материал	124,812,477.00	94,551,987.00
354	Хангамжийн материал	260,110,763.00	256,918,970.00
35410	Бичиг хэргийн материал	13,158,050.00	9,633,020.00
35420	Аж ахуйн материал	21,118,483.00	20,655,783.00
35450	Барилгын засварын материал	15,760,200.00	2,740,137.00
35470	Бусад хангамжийн материал	210,074,030.00	223,890,030.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,529,974,931.85	1,837,149,299.60
392	БИЕТ ХӨРӨНГӨ	1,839,196,528.97	1,224,679,830.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,366,823,394.00	4,388,629,094.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,665,048,504.22)	(3,258,921,294.95)
39207	Тавилга аж ахуйн эд хогшил	106,389,993.33	106,389,993.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,568,354.14)	(95,017,962.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,065,500.00	5,065,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(465,500.00)	(465,500.00)
39217	Ном	79,000,000.00	79,000,000.00
393	Биет бус хөрөнгө	690,778,402.88	612,469,469.31
39301	Програм хангамж	1,370,756,610.00	1,570,456,610.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(679,978,207.12)	(957,987,140.69)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,271,541,265.95	2,440,653,481.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,465,636.00	700,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,465,636.00	700,000,000.00
413213	Бусад зардлын өглөг	32,465,636.00	700,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,239,075,629.95	1,740,653,481.46
51	Засгийн газрын хувь оролцоо	3,239,075,629.95	1,740,653,481.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	344,839,013.00	344,839,013.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,894,236,616.95	1,395,814,468.46
51210	Өмнөх үеийн үр дүн	3,554,502,066.04	2,814,778,504.38
51220	Тайлант үеийн үр дүн	(660,265,449.09)	(1,418,964,035.92)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,271,541,265.95	2,440,653,481.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,361,679,426.98	8,384,676,700.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,294,598,192.98	784,724,297.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,294,598,192.98	784,724,297.40
120002	Хүүгийн орлого	120,220.25	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	713,125,812.73	780,834,057.40
120009	Бусад орлого	331,600.00	514,340.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	581,020,560.00	955,900.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	2,420,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,067,081,234.00	7,599,952,403.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,167,104,997.00	7,106,465,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,167,104,997.00	7,106,465,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,899,976,237.00	493,486,503.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого	1,899,976,237.00	493,486,503.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,021,944,876.07	9,803,640,736.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,021,944,876.07	9,803,640,736.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,890,142,864.98	9,668,506,048.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,272,160,890.24	1,573,055,780.43
210101	Үндсэн цалин	783,732,697.34	948,135,906.48
210102	Нэмэгдэл	231,796,118.30	325,861,339.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,741,864.72	132,950,170.00
210104	Урамшуулал	136,036,033.88	123,118,364.45
210105	Гэрээт ажлын хөлс	955,854,176.00	42,990,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	269,236,350.14	195,803,741.75
210201	Тэтгэврийн даатгал	222,458,750.64	136,101,145.62
210202	Тэтгэмжийн даатгал	11,549,324.71	15,163,248.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,467,107.08	7,423,224.72
210204	Ажилгүйдлийн даатгал	3,175,356.23	7,423,224.72
210205	Эрүүл мэндийн даатгал	22,585,811.48	29,692,897.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	320,755,625.00	354,353,280.00
210304	Байрны түрээс	320,755,625.00	354,353,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	92,620,392.26	19,006,102.11
210401	Бичиг хэрэг	17,718,390.00	1,872,820.00
210402	Тээвэр шатахуун	5,790,970.00	2,867,175.40
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	32,626,803.21	12,246,356.71
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	1,871,990.00	2,019,750.00
210408	Бараа материал акталсны зардал	34,612,239.05	-
2107	Томилолт зочны зардал	91,926,761.00	7,116,150.00
210701	Гадаад албан томилолт	90,824,761.00	-
210702	Дотоод албан томилолт	1,102,000.00	7,116,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,840,248,108.79	1,504,144,048.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,812,530,758.79	1,499,144,048.31
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх	27,717,350.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,003,194,737.55	6,015,026,946.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,166,600.00	4,667,774,446.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,969,383,315.77	512,379,280.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	985,644,821.78	834,873,219.68

Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,802,011.09	135,134,687.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	31,752,359.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,752,359.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	131,802,011.09	103,382,328.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	93,719,357.09	80,588,767.02
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	38,082,654.00	22,793,561.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(660,265,449.09)	(1,418,964,035.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(660,265,449.09)	(1,418,964,035.92)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,390,116,178.69	8,731,924,734.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	713,894,762.98	780,834,057.40
120	Нийтлэг татварын бус орлого	713,894,762.98	780,834,057.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	713,442,942.73	780,834,057.40
120009	Бусад орлого	451,820.25	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,676,221,415.71	7,951,090,676.85
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,167,104,997.00	7,106,465,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,509,116,418.71	844,624,776.85
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,509,116,418.71	844,624,776.85
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8,330,376,958.44	8,731,924,734.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,330,376,958.44	8,731,924,734.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,847,436,673.50	8,345,357,646.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,273,742,388.24	1,573,055,780.43
210101	Үндсэн цалин	785,314,195.34	948,135,906.48
210102	Нэмэгдэл	231,796,118.30	325,861,339.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,741,864.72	132,950,170.00
210104	Урамшуулал	136,036,033.88	123,118,364.45
210105	Гэрээт ажлын хөлс	955,854,176.00	42,990,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	256,893,559.49	195,756,946.36
210201	Тэтгэврийн даатгал	210,115,959.99	136,054,350.23
210202	Тэтгэмжийн даатгал	11,549,324.71	15,163,248.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,467,107.08	7,423,224.72
210204	Ажилгүйдлийн даатгал	3,175,356.23	7,423,224.72
210205	Эрүүл мэндийн даатгал	22,585,811.48	29,692,897.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	320,755,625.00	354,353,280.00
210304	Байрны түрээс	320,755,625.00	354,353,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,529,837.21	17,754,816.71
210401	Бичиг хэрэг	18,219,020.00	1,429,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,970,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,747,067.21	12,335,566.71
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,063,750.00	2,019,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	8,649,800.00
2107	Томилолт зочны зардал	91,926,761.00	7,116,150.00
210701	Гадаад албан томилолт	90,824,761.00	-
210702	Дотоод албан томилолт	1,102,000.00	7,116,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,811,474,069.79	1,431,155,609.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,811,474,069.79	1,426,155,609.41
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,068,114,432.77	4,757,515,263.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,135,050.00	4,261,906,457.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,021,979,382.77	495,608,806.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	482,940,284.94	386,567,087.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	31,752,359.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,752,359.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	482,940,284.94	354,814,728.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	93,894,357.09	80,588,767.02

Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	389,045,927.85	274,225,961.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	59,739,220.25	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	59,599,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,599,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	59,599,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(59,599,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	140,220.25	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	140,220.25
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	140,220.25	140,220.25

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	3,555,852,066.04	3,900,691,079.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(1,350,000.00)	(1,350,000.00)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,839,013.00	3,554,502,066.04	3,899,341,079.04
C07	Тайлант үеийн үр дүн		(660,265,449.09)	(660,265,449.09)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	2,894,236,616.95	3,239,075,629.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(79,458,112.57)	(79,458,112.57)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,839,013.00	2,814,778,504.38	3,159,617,517.38
D08	Тайлант үеийн үр дүн		(1,418,964,035.92)	(1,418,964,035.92)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	1,395,814,468.46	1,740,653,481.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,192,133,800.00	7,806,711,190.38	385,422,609.62	95.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,192,133,800.00	7,806,711,190.38	385,422,609.62	95.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,192,133,800.00	7,806,711,190.38	385,422,609.62	95.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,515,030,000.00	1,514,082,305.43	947,694.57	99.9
210101	Үндсэн цалин	950,164,000.00	948,135,906.48	2,028,093.52	99.8
210102	Нэмэгдэл	450,234,000.00	325,861,339.50	124,372,660.50	72.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,851,700.00	132,950,170.00	(131,098,470.00)	7179.9
210104	Урамшуулал	112,780,300.00	107,134,889.45	5,645,410.55	95.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,378,900.00	188,590,211.89	788,688.11	99.6
210201	Тэтгэврийн даатгал	128,777,600.00	128,887,615.76	(110,015.76)	100.1
210202	Тэтгэмжийн даатгал	15,150,300.00	15,163,248.81	(12,948.81)	100.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,575,200.00	7,423,224.72	151,975.28	98.0
210204	Ажилгүйдлийн даатгал	7,575,200.00	7,423,224.72	151,975.28	98.0
210205	Эрүүл мэндийн даатгал	30,300,600.00	29,692,897.88	607,702.12	98.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	354,353,300.00	354,353,280.00	20.00	100.0
210301	Байрны түрээс	354,353,300.00	354,353,280.00	20.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,943,100.00	17,754,816.71	188,283.29	99.0
210401	Бичиг хэрэг	1,429,500.00	1,429,500.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,977,000.00	1,970,000.00	7,000.00	99.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,506,800.00	12,335,566.71	171,233.29	98.6
210404	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,029,800.00	2,019,750.00	10,050.00	99.5
2105	Нормативт зардал	716,000.00	-	716,000.00	0.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	716,000.00	-	716,000.00	0.0
2106	Томилолт, зочны зардал	7,116,200.00	7,116,150.00	50.00	100.0
210601	Дотоод албан томилолт	7,116,200.00	7,116,150.00	50.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,795,567,300.00	1,431,155,609.41	364,411,690.59	79.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,786,361,500.00	1,426,155,609.41	360,205,890.59	79.8

Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	866,700.00	-	866,700.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,700.00	-	95,700.00	0.0
210805	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	777,800.00	-	777,800.00	0.0
210806	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,465,600.00	-	2,465,600.00	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,279,362,200.00	4,261,906,457.94	17,455,742.06	99.6
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	4,279,362,200.00	4,261,906,457.94	17,455,742.06	99.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,666,800.00	31,752,359.00	914,441.00	97.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,666,800.00	31,752,359.00	914,441.00	97.2
213201	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,288,300.00	31,752,359.00	535,941.00	98.3
213202	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	378,500.00	-	378,500.00	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,192,133,800.00	7,806,711,190.38	385,422,609.62	95.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,483,049,000.00	7,025,895,132.98	457,153,867.02	93.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	7,483,049,000.00	7,025,895,132.98	457,153,867.02	93.9
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	709,084,800.00	780,816,057.40	(71,731,257.40)	110.1
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	709,084,800.00	780,816,057.40	(71,731,257.40)	110.1
71	АЖИЛЛАГСАДЫН ТОО	72	54.00		74.6
620001	Удирдах ажилтан	1	1.00		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	70	53.00		74.3
620003	Үйлчлэх ажилтан	-	-		0.0
620004	Гэрээт ажилтан	1	4		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Итгэргээр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		844,624,776.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ		844,624,776.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		570,398,815.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		58,973,475.00
210101	Үндсэн цалин		-
210104	Урамшуулал		15,983,475.00
210105	Гэрээт ажлын хөлс		42,990,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		7,166,734.47
210201	Тэтгэврийн даатгал		7,166,734.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,649,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		8,649,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		495,608,806.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		495,608,806.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		274,225,961.38
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		274,225,961.38
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		844,624,776.85
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		844,624,776.85
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		844,624,776.85
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 199,700.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Захирлын А/28 дугаар тушаалын дагуу хийгдсэн 199,700.0 мянган төгрөгийн өртөг бүхий Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадварын түвшин тогтоох, өөрийн үнэлгээний "Chadla.eec.mn цогц систем" биет бус хөрөнгийг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч үр дүнг буруу тайлагнасан байна.	1	199,700.0					1	199,700.0				
	Дүн	1	199,700.0	-	-	-	-	1	199,700.0	-	-	-	-

3.2 Аудитаар нийт 138,233.8 мянган төгрөгийн 7 зөрчил илэрснээс 5,911.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 102,744.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 29,577.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Тус төвийн албан томилолтоор хөдөө орон нутагт ажилласан түрээсийн тээврийн хэрэгсэлүүдэд шатахууны	1	5,911.5	1	5,911.5								

Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	зардал олгохдоо ЗТХС-ын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормыг хэтрүүлэн 5,911.5 мянган төгрөгийн шатахууны илүү олгосон.												
2	Дотоодын шуудан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжтэй шуудан үйлчилгээний гэрээ байгуулж, 6,500.0 мянган төгрөгийн нууцын зэрэглэлтэй ЭЕШ-ын материалыг хүргэж өгөх, буцааж авах шуудан үйлчилгээний ажил гүйцэтгүүлсэн.	1	6,500.0	-	-	-	-	1	6,500.0			-	-
3	Боловсролын үнэлгээний төвийн захирал 2024.12.24-ний өдөр тус байгууллагад ажиллаж байгаа бүх ажилтанд 40 цагийн илүү цагийн нэмэгдэл олгох Б/52 дугаар тушаал гаргаж, нийт 39,984.7 мянган төгрөг олгосон байна.	1	39,984.7					1	39,984.7				
4	Тайлант онд 2 иргэнтэй "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, нийт 20,700.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон, үйл ажиллагааны чиглэл өөр компанид принтер засварын ажлын хөлс гэж 3,000.0 мянган төгрөг шилжүүлсэн, эдгээр ажлуудыг гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын нотлох баримт байхгүй байна.	1	23,700.0					1	23,700.0				
5	Тайлант онд 39,060.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн холбогдох заалтыг баримтлалгүй нэр бүхий 1 аж ахуйн нэгжээс шууд худалдан авалт хийсэн байна.	1	39,060.0					1	39,060.0				
6	"Гүйцэтгэлийн үнэлгээний асуулга боловсруулах гэрээ"-ний дагуу нэр бүхий 20 мэргэжилтэнд олгосон 23,077.5 мянган төгрөгийг	1	23,077.5					1	23,077.5				

Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	гүйцэтгэлийн акт болон тухайн ажлыг гүйцэтгэсэн эсэхийг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэсэн байна.												
7	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 275,474.6 мянган төгрөгийн дансны үнэ бүхий программ хангамж, 1,522,544.5 мянган төгрөгийн дансны үнэ бүхий тоног төхөөрөмжийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох үнийн саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй	1					1						
	Дүн	7	138,233.7	1	5,911.5	3	102,744.7	3	29,577.5	-	-	-	-

